



ӨВӨРХАНГАЙ АЙМАГ
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 10 сарын 20 өдөр

Дугаар А/2023

Бат-Өлзий сум

Золбин нохой, муур устгах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 дахь заалт, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1.9 дэх заалт, Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл гомдлыг шийдвэрлэх тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын төвийн золбин нохой, муур устгалыг 2023 оны 10 дугаар сарын 20-ны өдрөөс 2023 оны 10 дугаар сарын 23-ны хооронд зохион байгуулсугай.
2. Золбин нохой, муур устгалын ажлыг зохион байгуулахдаа аюулгүй байдлыг хангаж, аюулгүй ажиллагааны заавар журмыг мөрдүүлэхийг Цагдаагийн тасгийн дарга (Д.Энх-Амгалан Цагдаагийн хошууч), нохой устгах иргэнтэй гэрээ байгуулж, хяналт тавьж ажиллахыг багийн Засаг дарга (Г.Бямбагарав), гэрээ байгуулсан иргэнтэй өдөр тутмын хяналтаар явж ажиллахыг Байгаль орчны асуудал хариуцсан мэргэжилтэн (Б.Янжиндулам) нарт тус тус үүрэг болгосугай.
3. Нохой, муур устгалын зардалд шаардагдах 3,700,000 (гурван сая долоон зуун мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангаас зарцуулахыг Засаг даргын Тамгын газрын гэрээт нягтлан бодогч (Б.Пүрэвсүрэн)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА

С.АМГАЛАН